Коронавируст халдвар (COVID-19)-ын үеийн хөл хорионы нөхцөлд ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтнүүдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг үнэлсэн цахим судалгааны дүн

Б.Баттуяа[1,2], Б.Лувсанняндаг[1,3], Э.Мөнх[1,3], В.Өнөмөнх[4], Д.Оюунсүрэн[1], З.Хишигсүрэн[1], Р.Оюунгэрэл[2,5]

[1]АШУҮИС, АУС, Сэтгэцийн Эрүүл Мэндийн Тэнхим
[2] Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв
[3] Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв
[4]Нийслэлийн Эрүүл Мэндийн Газар
[5]АШУҮИС, АУС, Халдварт Өвчин Судлалын Тэнхим
battuya26@gmail.com 90080845

Товч утга.

Үндэслэл: Шинэ *SARS-CoV-2* халдварын цар тахлаас улбаатай хөл хорионы энэ үеэр эрүүл мэндийн ажилтнууд болон олон нийтийн дунд гэмтлийн дараах стрессийн эмгэг, сэтгэлийн түгшилт, сэтгэл гутрал зэрэг сэтгэцийн шинжүүд бүртгэгдсээр байгаа билээ. Энэхүү судалгааны зорилго нь хөл хорионы нөхцөлд ажиллаж буй эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн дунд тохиолдож байгаа сэтгэцийн эрүүл мэндийн зарим асуудлыг илрүүлэхэд чиглэсэн болно.

Материал, аргазүй: Энэхүү судалгааг тойм судалгааны агшингийн загвараар хийв. Бид тусгайлан боловсруулсан цахим асуумжийг ашиглан мэдээллийг цуглууллаа.

Үр дүн: Судалгаанд эрүүл мэндийн бүх шатны байгууллагад ажилладаг 21-58 насны нийт 161 ажилтан оролцсоноос 61 нь эрэгтэй, 100 нь эмэгтэй хүйсийнх, дундаж нас 39.5 ± 8.8 байв. Насны бүлгээр нь авч үзвэл 25-34 насныхан илүү олон байлаа. Нийт судалгаанд хамрагдагсдын 67.7% (n=109) нь 7 хүртэлхи цагийн хугацааг гар утасны хэрэглээнд зарцуулж байгаа, 74.5% (n=120) нь халдвараас айж байгаа гэж үнэлсэн бөгөөд 29.8% (n=48) нь маш ихээр халдвараас айж байна хэмээн хариулжээ. Судалгаанд хамрагдагсдын 59% нь сэтгэлийн түгшүүртэй, 44% нь сэтгэл гутралд орсон байлаа. Дүүргийн эрүүл мэндийн нэгдэлд ажиллагсдад ажлаас халшрах хамшинжийн илрэлийн түвшин эрүүл мэндийн бусад шатлалын байгууллагад ажилладаг оролцогчдоос илүү, ялангуяа ажлын бүтээмж бууралтын түвшин бусдаас илүү өндөр байсан боловч статистик ач холбогдолгүй (x^2=2.64; p=0.45) байв.

Дүгнэлт: *Хөл хорионы нөхцөлд ажиллаж буй бүх шатны* эрүүл мэндийн ажилтнуудын 59% нь сэтгэлийн түгшүүртэй, 44% нь дунд зэргээс хүнд зэргийн сэтгэл гутралтай, 74.5% нь халдвараас айх айдастай байлаа. Дүүргийн эрүүл мэндийн нэгдэлд ажиллагсдад ажлаас халшрах хамшинжийн илрэлийн түвшин илүү өндөр боловч статистик ач холбогдолгүй (x^2=2.64; p=0.45) байв.

Түлхүүр үг: КОВИД-19, дэгдэлт, сэтгэцийн шинжүүд, эрүүл мэндийн ажилтан

СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ:

Халдварт өвчний цар тахал хэлбэрийн дэгдэлт нь **нэгэн зэрэг олон хүний эрүүл мэнд, амь насанд аюул учруулж болзошгүй аюултай, хувь хүний үнэт зүйлсийг сүйрүүлэн хүнд гарз хохирол учруулах нөлөөтэй, цаг бусын, гэнэтийн сүйрүүлэх хүчтэй стрессийн нэг төрөл юм** [1]. 2019 оны сүүлчээр БНХАУ-д хүн амын дунд эндэгдэл өндөртэй уушгины үрэвсэл тархаж эхэлсэн тухай ДЭМБ-д мэдээлсэн коронавирусын шалтгаантай байсан ба ДЭМБ шинэ коронавирүсээр сэдээгдсэн өвчнийг COVID-19 хэмээн нэрлэж, 2020 оны 3 сарын 11-д цар тахлын хэмжээнд хүрснийг зарласан билээ. 2020 оны 12 сарын 12-ны байдлаар, дэлхийн 218 улс орон, дэвсгэр нутгийн 49 сая гаруй хүн уг халдвараар өвчилж, 1.5 сая гаруй хүн нас барааd байна[2,3]. COVID-19-ийн халдвартай холбоотой хийгдсэн эрт үеийн судалгаануудын **дүгнэлтэнд уг халдвараар**

өвчлөгсөд, эмчлүүлэгч, тусгаарлагдагсад, эмч эмнэлгийн ажилтны сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлон үнэлэх, сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэрэгцээг тогтоох шаардлагатай болохыг санал болгосон байдаг [4].

Бие махбодын болон нийгмийн тусгаарлалт, өдөр тутмын амьдралын хэв маягийн өөрчлөлт, санхүүгийн стресс, хоол хүнсний аюулгүй байдал зэрэг нь бидний болон нийгмийн стресст үзүүлэх хариу урвалыг өдөөсөн нь энэхүү цар тахлын улмаас улам бүр эрчимжиж хувь хүмүүсийн оюун санааны сайн сайхан байдал тогтвортой байдалд заналхийлж байгаа юм [5,6].

COVID-19-ийн халдварын цар тахалын голомтонд гар бие оролцон ажиллаж буй халдвартын, дотрын болон эрчимт эмчилгээний тасгийн эмч, эмнэлгийн ажилчдын дунд хийгдсэн 14 судалгааны а**жлыг нэгтгэн үнэлсэн үр дүнгээс харахад, эмч эмнэлгийн ажилчдын стрессийн туршлагаас хамааран сэтгэл түгшилт, сэтгэл гутрал илүү илэрч байсан бөгөөд сэтгэлзүйн хямралын хүндийн зэрэг нь нас, хүйс, ажил мэргэжил, мэргэшил, гүйцэтгэсэн үйл ажиллагааны төрөл, COVID-19-ийн халдвартай өвчинтэй хир ойр байсантай хамааралтай байсан байна**[7].

Манай орны хувьд 2020 оны 3-р сард шинэ коронавирүст халдварын анхны зөөвөрлөгдсөн тохиолдол, 2020 оны 11-р сарын 7 өдөр дотоодын халдварын анхны тохиолдол бүртгэгдсэнээс хойш 2020 оны 12-р сарын 12-ны өдрийн байдлаар нийт 906 батлагдсан тохиолдол, үүнээс Улаанбаатар хот, 6 аймгийн хэмжээнд нийт 454 дотоодын халдварын тохиолдол бүртгэгдээд байгаа билээ [8]. Шинэ коронавирус халдвараар дотооддоо халдварласан ахны тохиолдол бүртгэгдсэн өдрөөс эхлэн өнөөг хүртэл Улсын Онцгой Комиссын шийдвэрээр улс орныг хамарсан хатуу хөл хорионы дэглэм зарласан нөхцөлд ажил үүргээ хэвийн үргэлжлүүлэн гүйцэтгэж буй бүх шатны эрүүл мэндийн байгууллагын эмч мэргэжилтнүүдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдалд эрсдэл үүсч болзошгүй байгаа нь энэхүү судалгааны ажлын үндэслэл болсон юм.

ЗОРИЛГО:

Хөл хорионы дэглэмийн нөхцөлд ажиллаж байгаа эмч мэргэжилтнүүдийн сэтгэцийн эрүүл мэндийн зарим асуудлыг судлан тодорхойлох

СУДАЛГААНЫ АЖЛЫН ЁС ЗҮЙ:

Судалгааны ёс зүйн асуудлыг Эрүүл мэндийн яамны Анагаах ухааны ёс зүйн хяналтын хорооны хурлаар хэлэлцүүлж судалгаа хийх ёс зүйн зөвшөөрөл авсан (2020 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн хурлын тогтоол, дугаар № 172). Судалгаанд хамрагдагсдаас таниулсан зөвшөөрлийн цахим хуудсаар дамжуулан судалгаанд оролцох зөвшөөрөл авсан болно.

Судалгааны материал, аргазүй: Судалгааг тойм судалгааны агшингийн загвараар зохион байгуулж, **хөл хорионы нөхцөлд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй** эмнэлгийн ажилтн**ыг хамруулав.** ЭМЯ-ны захиалгаар БСШУСЯ-ны ШУТС-ийн санхүүжилттэй АШУҮИС, ХӨСҮТ хамтран гүйцэтгэсэн “Монгол улсад бүртгэгдсэн шинэ коронавирүст халдвар (*SARS-COV-2*)-ын эмнэлзүйн судалгаа”-ны төсөлт ажлын хүрээнд бид эрүүл мэндийн бүх шатны байгууллагуудад ажиллаж буй эмч эмнэлгийн мэргэжилтнүүдээс тусгайлан боловсруулсан асуумж судалгааны цахим картыг боловсруулан ашиглаж зохих мэдээллийг цуглуулсан болно.

ҮР ДҮН:

Судалгаанд хамрагдагсад нь 21-54 насны, эрэгтэй 61, эмэгтэй 100 байсан ба дундаж нас 35.9± 8.8 байлаа. Насны бүлгээр авч үзвэл 25-54 насныхан илүү байв. Нийт оролцогчдын 16.8% (n=27) нь өрхийн эрүүл мэндийн төвд, 40.9% (n=66) нь дүүргийн нэгдсэн эмнэлэгт, 13.7% (n=22) нь аймгийн нэгдсэн эмнэлэгт, 24.2% (n=39) нь төрөлжсөн мэргэжлийн туслажийн түвшинд ажиллаж байгаа бөгөөд ердөө 0.04% (n=7) нь бүсийн оношилгоо эмчилгээний төвд ажиллаж байгаа ажилтнууд байлаа. Нийт судалгаанд хамрагдагсдын 67.7% (n=109) нь 7 хүртэлхи цагийн хугацааг гар утасны хэрэглээнд зарцуулж байв. Хөл хорионы нөхцөлд ажиллаж байгаа нөхцөлд халдвар авахаас айх айдас байсан эсэхийг Ликертийн 0-5 оноог ашиглан үнэлүүлэхэд судалгаанд оролцсон нийт эрүүл мэндийн ажилтны 10% буюу 16 нь айдас байгаагүй гэсэн бол, 90% нь халдвар авахаас айх айдастай, үүнээс 29.8% (n=48) нь маш их айдастай байсан гэж хариулсан байв. Нарийвчлан авч үзвэл судалгаанд оролцсон өрхийн эрүүл мэндийн төвд ажиллагсдын 77.8% (n=21) халдвар авахаас айх айдастай байсан хэдий ч статистик ач холбогдол бүхий ялгаагүй байлаа (x^2=8.59, p=0.93).

Хүснэгт 1-ээс үзвэл судалгаанд хамрагдсан эрүүл мэндийн ажилтны 59% (n=95) нь сэтгэл түгшилттэй байснаас 46.6% (n=75) нь бага зэргийн сэтгэл түгшилттэй; 44.1% (n=71) нь сэтгэл гутралтай байснаас 35.4% (n=57) нь бага зэргийн сэтгэл гутралтай байжээ.

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын сэтгэцийн эрүүл мэндийн зарим үзүүлэлт

Үзүүлэлт	Ажиллаж буй эрүүл мэндийн тусламжийн шатлал					Нийт	
	Өрхийн ЭМТ	Дүүргийн НЭ	Аймгийн НЭ	БОЭТ	Төрөлжсөн мэргэжлийн төв		
Сэтгэл түгшилтийн түвшин							
Түгшилтгүй	10	25	7	3	21	66	x2=9.44 p=0.66
Бага зэрэг	14	33	10	4	14	75	
Дунд зэрэг	1	6	4	0	2	13	
Хүнд зэрэг	2	2	1	0	2	7	
Бүгд	27	66	22	7	39	161	
Сэтгэл гутралын түвшин							
Гутралгүй	18	37	8	5	22	90	x2=13.79 p=0.61
Бага зэрэг	8	22	11	2	14	57	
Дунд зэрэг	0	6	1	0	2	9	
Хүндэвтэр	1	0	1	0	0	2	
Хүнд зэрэг	0	1	1	0	1	3	
Бүгд	27	66	22	7	39	161	
Ажлаас халшрах хам шинжийн сэтгэлээрээ мэдрэх чадварын түвшин							
Илрээгүй	3	8	1	0	8	20	x2=14.59 p=0.26
Бага зэрэг	12	27	11	6	21	77	
Дунд зэрэг	5	14	7	1	4	31	
Өндөр	7	17	3	0	6	33	
Бүгд	27	66	22	7	39	161	
Ажлаас халшрах хам шинжийн сэтгэл хөдлөлийн түвшин							
Илрээгүй	2	1	1	0	3	7	x2=8.52 p=0.74
Бага зэрэг	18	47	16	7	31	119	
Дунд зэрэг	6	14	4	0	4	28	
Өндөр	1	4	1	0	1	7	
Бүгд	27	66	22	7	39	161	
Ажлаас халшрах хам шинжийн хувь хүний бүтээмжийн түвшин							
Илрээгүй	14	23	6	1	1	58	x2=9.72 p=0.64
Бага зэрэг	7	13	7	2	11	40	
Дунд зэрэг	1	7	2	0	3	13	
Өндөр	5	23	7	4	11	50	
Бүгд	27	66	22	7	39	161	

Ажлаас халшрах хамшинжийн сэтгэлээрээ мэдрэх чадвар нийт оролцогчдын 87.6% (n=141) –д нь тодорхойлогдсоны 21.9-23.4%-д нь дундаас өндөр түвшинд тодорхойлогдлоо. Уг хамшинжийн сэтгэл хөдлөлийн илрэл нийт оролцогчдын 83.2% (n=134) –д нь тодорхойлогдсоны ердөө 20.9-5.2%-д нь дундаас өндөр түвшинд тодорхойлогдсон байна. Харин хувь хүний бүтээмжийн бууралт 63.9% (n=103)-д нь илэрсэнээс 48.5% (n=50)-д нь бүтээмжийн бууралт өндөр түвшинд тодорхойлогдсон байв. Ялангуяа дүүргийн эрүүл мэндийн нэгдэлд ажилладаг оролцогчдод ажлаас халшрах хамшинжийн 3 үзүүлэлт бусад оролцгчдынхоос илүү их тодорхойлогдсон боловч статистик ач холбогдолгүй (p=0.26-0.74) байлаа.

ХЭЛЦЭМЖ:

Хүн төрөлхтөн сүүлийн 100 жилд 7 цар тахалтай нүүр тулан даван туулах явцдаа олон улсын эрүүл мэндийн мэргэжилтэн, эмч нар тэдгээр цар тахал хүний төрх үйл, харилцаа холбоонд үзүүлсэн нөлөөлөл нь цаг хугацаа өнгөрөх тусам сэтгэлийн шалтгаант өвчин эмгэг үүсгэх үр дагаварт хүргэсэн болохыг судлан тогтоосон байдаг [9]. Хорио цээрийн дэглэмд удаан хугацаагаар байгаа хэн бүхэнд стресс, түгшүүр, айдас, нойргүйдэл, будлиу болох гэх зэрэг шинжүүд илрэхээс гадна нийгмээс ялгаварлан гадуурхагдах байдал тохиолдож байгааг судлаачид цохон тэмдэглэж байна [10]. Шинэ коронавируст халдварын тусгаарлалтанд ажиллаж байсан эмч, сувилагч нарын дунд сэтгэл түгшилт, сэтгэл гутрал, айдас өндөр түвшинд тодорхойлогдож байсныг Их Британи, Ливаны болон Хятадын судлаачид судлан тогтоожээ [11,12].

Бидний судалгааны дүнгээс харахад манай судалгаанд хамрагдагсдын 59%-д нь сэтгэл түгшилт, 44.1%-д нь сэтгэл гутралын байдал багаас хүнд зэргийн түвшинд тодорхойлогдсон бөгөөд 5.2%-48.5%-д нь ажлаас халшрах хамшинжийн илрэлүүд илэрч байгаагаас үзвэл хөл хорины нөхцөлд ажиллаж буй бүх шатны эрүүл мэндийн байгууллагын ажилтны дунд стресс их байна хэмээн үнэлж болохоор байна.

ДҮГНЭЛТ:

*Х*өл хорионы нөхцөлд ажиллаж буй бүх шатны эрүүл мэндийн ажилтнуудын 59% нь сэтгэлийн түгшүүртэй, 44% нь дунд зэргээс хүнд зэргийн сэтгэл гутралтай, 74.5% нь халдвараас айх айдастай байлаа. Дүүргийн эрүүл мэндийн нэгдэлд ажиллагсдад ажлаас халшрах хамшинжийн илрэлийн түвшин илүү өндөр боловч статистик ач холбогдолгүй (x^2=2.64; p=0.45) байв.

ТАЛАРХАЛ:

Энэхүү судалгааг зохион байгуулахад дэмжин ажилласан ЭМЯ, НЭМГ болон судалгаанд хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд, хамтран ажилласан багийнхаа хамт олонд гүн талархал илэрхийлье.

НОМ ЗҮЙ:

1. Бямбасүрэн С. “Гамшгийн үеийн сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал. Улаанбаатар хот. 2002 он. х. 3
2. Нямдаваа П. Цартахал. Халдварт өвчин судлалын Монголын сэтгүүл.2020 №4 (93) х. 1
3. *https://covid19.who.int/* accessed on 14 October 2020
4. Shalev D, Shapiro PA. Epidemic psychiatry: The opportunities and challenges of COVID-19. *Gen Hosp Psychiatry*. 2020;64:68-71. DOI:10.1016/j.genhosppsych.2020.03.009
5. Assari S, Habibzadeh P. The COVID-19 Emergency Response Should Include a Mental Health Component. Arch Iran Med. 2020 Apr 1;23(4):281-282. doi: 10.34172/aim.2020.12. PMID: 32271604.
6. Ivbijaro G, Brooks C, Kolkiewicz L, Sunkel C, Long A. Psychological impact and psychosocial consequences of the COVID 19 pandemic Resilience, mental well-being, and the coronavirus pandemic. *Indian J Psychiatry*. 2020;62(Suppl 3):S395-S403. doi:10.4103/psychiatry.IndianJPsychiatry_1031_20
7. Bohlken J, Schömig F, Lemke MR, Pumberger M, Riedel-Heller SG. COVID-19 Pandemic: Stress Experience of Healthcare Workers - A Short Current Review. Psychiatr Prax. 2020 May;47(4):190-197. DOI: 10.1055/a-1159-5551. Epub 2020 Apr 27.
8. ЭМЯ, нөхцөл байдлын мэдээ. https://covid19.mohs.mn/p/cat/post/57
9. Esterwood E, Saeed SA. Past Epidemics, Natural Disasters, COVID19, and Mental Health: Learning from History as we Deal with the Present and Prepare for the Future. *Psychiatr Q*. 2020;91(4):1121-1133. doi:10.1007/s11126-020-09808-4
10. Dubey S, Biswas P, Ghosh R, et al. Psychosocial impact of COVID-19. *Diabetes Metab Syndr*. 2020;14(5):779-788. doi:10.1016/j.dsx.2020.05.035
11. Lancee, W.J., Maunder, R.G., Goldbloom, D.S. Prevalence of psychiatric disorders among Toronto hospital workers one to two years after the SARS outbreak. Psychiatr. Serv, 2008; 59: 91–95.
12. Nickell, L. A. Psychosocial effects of SARS on hospital staff: Survey of a large tertiary care institution. Canadian Medical Association Journal, 2004;170(5): 793–798

Results of online assessment the mental health problems of health care professionals working in lockdown situation during the COVID-19

Battuya B[1,2], Luvsannyandag B[1,3], Munkh E[1,3], Unumunkh V[4], Oyunsuren D[1], Khishigsuren Z[1], Oyungerel R[2,5]

[1]Department of Mental Health, SoM, MNUMS
[2]National Center of Communicable Diseases
[3]National Center for Mental Health
[4]Metropolitian Health Department
[5]Department of Communicable Diseases, SoM, MNUMS
battuya26@gmail.com 90080845

ABSTRACT

Introduction: During the lockdown period due to COVID-19 pandemic, psychiatric symptoms including posttraumatic stress disorder, anxiety, and depression registering both in health care workers and the public. The goal of this study was to identify some mental health problems among health professionals, are working in lockdown situation due to SARS-CoV-2 outbreaks.

Methods: A descriptive and cross-sectional research design was conducted. We used a semi-structured online questionnaire.

Results: Totally 161 respondents, aged 21-58 who are working at all level of health care setting were completed our online questionnaire and 100 of them were females with an average age of 39.5±8.8. By age group, there are more subjects aged 25-34. Of the total respondents, 36.6% (n=59) spend more than 7 hours using cell phones; 74.5% (n=120) rated they were afraid of infection, and 29.8% (n=48) rated they were very scared. 59% of the total respondents have anxiety, and 44% have depressed. The majority of the respondents are district health care workers and they have more burned in workplace than other respondents, especially level of personal accomplishment more lower than others but was not statistically significant (x2=2.64; p=0.45).

Conclusion: Of total respondents, working at all level health care setting, 59% have anxiety, and 44% are depressed as moderate-to-severe; and 74.5% are afraid from infection. District health care workers have a high incidence of workplace burnout syndrome without statistically significant (x2=2.64; p=0.45).

Keywords: COVID-19, outbreak, psychiatric symptoms, health staff